

## Химийн бодистой ажиллагсдад зориулсан сурах бичиг

Монгол хэл

Аюулгүй ажиллагааг хангах үүднээс  
химийн бодисын шинж чанарыг  
таньж мэдэцгээе!

## Удиртгал

Энэхүү сурах бичигт ажилчид химийн бодистой харьцахдаа мэдэж байх шаардлагатай химийн бодисын хор аюулын мэдээллийг хэрхэн унших талаар нэгтгэв.

### Текстийн агуулга

1. Химийн бодистой харьцахын өмнө тэдгээрийн хор аюулын талаар шалгана уу!
2. Шошгон дээрх химийн бодисын мэдээллийг уншихдаа анхаарах зүйлс
3. Шошгон дээрх пиктограм ямар утгатай вэ?
4. Химийн бодисоос үүдэлтэй үйлдвэрийн осол хэрхэн гардаг вэ?
5. Химийн бодистой харьцахад чиглэсэн анхааруулга (Шошгыг анхааралтай шалгана уу )!
6. Өдөр тутмын ажиллагаанд баримтлах шаардлагатай зүйлс

1. Химийн бодистой харьцахын өмнө тэдгээрийн хор аюулын талаар шалгана уу!

**Аль нь аюултай вэ?**

**Аль нь хортой вэ?**



**Та химийн бодисын хор аюулын талаар мэдэх үү?**



**Шошгон дээрх химийн бодисын хор аюулын талаарх  
хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдээллийг  
шалгахаа бүү мартаарай!**

Үүнийг ашиглахаасаа өмнө шошгыг заавал шалгана уу.

2. Шошгон дээрх химийн бодисын мэдээллийг уншихдаа анхаарах зүйлс GHS шошготой танилцъя. Шошгон дээр дараах 5 зүйл болон ханган нийлүүлэгчийн мэдээллийг харуулсан байна.










- ① [Химийн бүтээгдэхүүний нэр](#)
- ② [Анхааруулга](#)
- ③ [Пиктограм](#)
- ④ [Хор аюулын талаарх мэдээлэл](#)
- ⑤ [Урьдчилан сэргийлэх анхааруулга](#)



- ① Химийн бүтээгдэхүүний нэрийг шалган, таны ашиглах бүтээгдэхүүн мөн эсэхийг нягтална үү. Худалдан авсан савыг өөр саваар солихдоо шошгыг сайтар наалдуулна үү.
- ② Хор аюулын зэргээс хамааран "DANGER", эсвэл "WARNING" гэсэн дохио үг бичигдсэн байна. "DANGER" гэдэг нь "аюултай!" гэсэн үг! "WARNING" гэдэг нь "болгоомжтой бай" гэсэн үг!
- ③ Зурган тэмдэглэгээ нь ямар төрлийн хор хөнөөлтэйг харуулна. Химийн бодисын хор аюулыг хараад шүүд таньдаг болох үүднээс пиктограмуудтай танилцъя.
- ④ Хор аюулын талаарх мэдээлэл нь хор аюулын төрөл, ангилалд үндэслэн тайлбарласан байдаг.
- ⑤ Харьцахдаа анхаарах зүйлсийг тайлбарласан байна. Анхааруулгыг шалгаснаар та химийн бодисын аюултай нөхцөл, ажилтны аюултай ажиллагааг олж мэдэх боломжтой. Үүнийг анхааралтай уншина үү

### 3. Шошгон дээрх пиктограм ямар утгатай вэ?

Пиктограмын утгыг дараах жагсаалтаар харуулав . Пиктограмыг хараад хор аюулыг тодорхойлж чаддаг болцгооё .


<p>Шатамхай</p> 	<p>Шатамхай хий</p> <p>Шатамхай шингэн</p> <p>Шатамхай хатуу бодис</p> <p>Өөрөө урвалд орогч бодисууд ба холимогууд</p>	<p>Исэлдүүлэгч</p> 	<p>Исэлдүүлэгч хий</p> <p>Исэлдүүлэгч шингэнүүд</p> <p>Исэлдүүлэгч хатуу бодисууд</p>	<p>Тэсрэмтгий</p> 	<p>Тэсрэмтгий бодисууд (бүлэг 1.1-1.4)</p> <p>Өөрөө урвалд орогч бодисууд ба холимогууд</p> <p>Органик хэт ислүүд</p>
<p>Зэврэмтгий</p> 	<p>Металл зэврүүлэгч бодис</p> <p>Арьс үрэвсүүлэгч ба цочроогч бодис (ангилал 1)</p> <p>Нүд хүчтэй гэмтээгч ба цочроогч бодис (ангилал 1)</p>	<p>Савласан хий</p> 	<p>Даралтат хий</p>	<p>Амь насанд аюултай</p> 	<p>Онцгой хортой (ангилал 1-3)</p>
<p>Анхаар</p> 	<p>Онцгой хортой (ангилал 4)</p> <p>Арьс цочроогч (ангилал 2)</p> <p>Нүд цочроогч (ангилал 2A)</p> <p>Арьс эмзэглүүлэгч</p> <p>Тодорхой эрхтнийг хордуулагч (ангилал 3) бусад</p>	<p>Байгаль орчин</p> 	<p>Усан орчинд хортой бодис</p>	<p>Эрүүл мэндэд хортой</p> 	<p>Амьсгалын замыг эмзэглүүлэгч бодис</p> <p>Нөхөн үржихүйн эсийн мутаген</p> <p>Хорт хавдар үүсгэгч</p> <p>Нөхөн үржихүүд хортой</p> <p>Тодорхой эрхтнийг хордуулагч (ангилал 1, 2) бусад</p>

#### 4. Химийн бодисоос үүдэлтэй үйлдвэрийн осол хэрхэн гардаг вэ?

##### Үйлдвэрлэлийн осол ямар доголдол, шалтгаанаас үүдэлтэй вэ?

Үйлдвэрлэлийн осол гарах хоёр шалтгаан бий.

- Ажлын байрны орчин нөхцөл болон тоног төхөөрөмж, түүхий эд зэргийн **"Аюултай нөхцөл"**
- Ажилчдын буруу ажиллагаанаас үүдсэн **"Аюултай нөхцөл"**



Ажлын байран дээр химийн бодисоос үүдэлтэй үйлдвэрлэлийн осол хэрхэн гардаг вэ?

Химийн бодисын аюултай нөхцөл болон ажилчдын аюултай ажиллагаа давхацсанаар үйлдвэрлэлийн осол гардаг. Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд химийн бодисын аюултай нөхцөл, химийн бодистой харьцахдаа гаргадаг аюултай ажиллагааг мэдсэнээр урьдчилан сэргийлэх боломжтой. Аюултай нөхцөл, аюултай ажиллагаанаас зайлсхийхэд чиглэсэн тэмдэглэгээнүүд нь шошгон дээр бичигдсэн байгаа

## 5. Химийн бодистой харьцахдаа анхаарах зүйлс (Шошгыг сайтар шалгана уу!)

Хор аюулын онцлогоос шалтгаалан анхааруулах тэмдэглэгээнүүд байдаг. Дараах жишээтэй адил тайлбар байдаг. Анхааруулгыг дагаж мөрдөн, химийн бодисын аюултай нөхцөл үүсгэхгүй байх, харьцахдаа аюултай ажиллагаа гаргахгүй байх нь нэн чухал.

### Химийн бодисыг аюултай байдалд орхихгүй байх

Шошгон дээр бодистой харьцах, хадгалах үеийн анхааруулга зэрэг бичигдсэн байх бөгөөд анхааруулга дээр заагдсан бүгдийг баримтлах шаардлагатай.

**Жишээ нь:** Онцгой хортой, шатамхай шингэн г.м анхааруулга.

- Агааржуулалт сайтай газар хадгалах. Савыг битүү, таглаатай байлгах.
- Агааржуулалт сайтай газар хадгалах. Сэрүүн газар тавих.

### Химийн бодистой харьцахдаа аюултай ажиллагаа гаргаж болохгүй

Шошгон дээрх анхааруулгыг зөрчиж болохгүй.

**Жишээ нь:** Нөхөн үржихүйд хортой, хорт хавдар үүсгэгч г.м анхааруулгууд

- Ашиглахын өмнө зааврыг олж үзнэ үү
- Бүх аюулгүйн зааварчилгаа анхааруулгыг бүрэн уншиж ойлготлоо бодистой харьцахгүй байна уу.

## 6. Өдөр тутмын ажилдаа баримтлах зүйлс

Химийн бодисын шинж чанарыг таньж мэдэн дараах зүйлсийг өдөр тутмын ажиллагааныхаа үеэр сайтар ажиглана уу.

- ◆ Тогтсон ажлын дараалал (ажлын стандарт) -ыг даган мөрдөж, түүнээс өөр аргаар ажиллахгүй байх.
- ◆ Хамгаалах хэрэгслийн ач холбогдлыг бүрэн ойлгож, зохих ёсоор нь өмсөх.
- ◆ Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах үүднээс юуг хийж болох, юуг хийж болохгүйг ойлгож ухамсарлах.
- ◆ Ажлын дарааллыг мэдэхгүй тохиолдолд хариуцсан ажилтнаас заавал асууна уу.
- ◆ Дадсан ажил байсан ч, ажиллаж байхдаа болон шийдвэр гаргах үедээ анхаарал болгоомжтой байгаарай.